



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/26

Ханх сум

**Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах,  
цэвэр аюулгүй орчин бүрдүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5 дахь заалт, Орчны бохирдлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай, сад, цэцэрлэгт хүрээлэнгийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 04 дугаар сарын 23-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдөр хүртэл сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээний ажилд оролцсон сурагч, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж ажиллах төлөвлөгөө, удирдамж гарган биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасаг, Засаг даргын орлогч (Б.Баттүвшин)-д, хамтран ажиллах гэрээний дагуу хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тогтоосон координат цэгт тээвэрлэн булшлахыг Есүй-ОД ХХК захирал А.Дэлгэрдаваа, захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хамтран ажиллахыг Тураг багийн Засаг дарга Ш.Отгонжаргал, Хороо 2-р багийн Засаг дарга Б.Анхбаяр, Турт 3-р багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Э.Мөнхжаргал, Баясгалант 4-р багийн Засаг дарга Б.Бямбабаяр нарт үүрэг болгосугай.

3. Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах цэвэр аюулгүй орчин бүрдүүлэхэд шаардагдах шатах тослох материал, хамгаалах хувцас хэрэгсэл болон бусад зардлыг хуулийн дагуу тооцож шийдвэрлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Баасансүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Л.ДАВААБАЯР